



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/161/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Н.Дэмбэрэлдорж
Утас: 99299027
Цахим хаяг: ndembee.@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.4.3 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.4.4 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Залруулсан алдаа	15
<i>Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй</i>	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ШОЛПАНХАН ТАНАА

2023.02.14 № 02/39
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжилийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулахаргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталж мөрдсөн байна.

Дулаанаар хангах гэрээгээр үүссэн өр төлбөрөөс 20,5 сая төгрөгийг төлж, үлдэх 15,4 сая төгрөгийн өрийг нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй зөвшилцөн хассан байна

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2022онд нийт 90 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 76 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамруулж, биелэлт 84,4 хувьтай байна

021020115

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 89.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан / төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33375497.68	18311329.12
33	АВЛАГА	2203035.68	693042.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2203035.68	640256.12
335	Бусад авлага	0	52786
3351	Байгууллагаас авах авлага	0	52786
35	БАРАА МАТЕРИАЛ	31172462	17618287
354	Хангамжийн материал	31172462	17618287
35410	Бичиг хэргийн материал	37500	83000
35420	Аж ахуйн материал	39000	2921180
35460	Хүнсний материал	3937107	7815957
35470	Бусад хангамжийн материал	27158855	6798150
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	200018390.3	213196850.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	200018390.3	213196850.9
392	Биет хөрөнгө	192064590.3	205243050.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	170272480	170272480
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8513624.16	-11351498.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20459756	20459756
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12782371.1	-15837039.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27698182.82	27698182.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18822652.28	-20672353.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	13268990	38268990
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-4079295
39217	Ном	483829	483829
393	Биет бус хөрөнгө	7953800	7953800
39301	Програм хангамж	457000	457000
39303	Бусад биет бус хөрөнгө	7496800	7496800
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	233393888	231508180
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	626400	217922
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	626400	217922
413	Өглөг	626400	217922
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	489870	217922
4136	Бусад өглөг	136530	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	136530	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	173300240	171823010
51	Засгийн газрын хувь оролцоо	173300240	171823010
512	Хуримтлагдсан үр дүн	61894719.16	60417489.24
51210	Өмнөх үеийн үр дүн	61894719.16	61894719.16
51220	Тайлант үеийн үр дүн	0	-1477229.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111405520.8	111405520.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	233393887,96	231508180,04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339466885	336509705
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63747485	20920705
120	Нийтлэг татварын бус орлого	2012085	20920705
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	433600	20920705
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	433600	20920705
120009	Бусад орлого	1578485	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	61735400	0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	61735400	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275719400	315589000
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	264723985	315589000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	36961000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264723985	278628000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10995415	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10995415	0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	279724953.9	337986934.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	279724953.9	337986934.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255801447.9	337986934.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188310935	218720985.2
210101	Үндсэн цалин	143052203	164927232.2
210102	Нэмэгдэл	45258732	52249954
210104	Урамшуулал	0	1543799
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25069794.32	26501746.36
210201	Тэтгэврийн даатгал	17435340.35	17416573.14
210202	Тэтгэмжийн даатгал	1937709.35	2195523.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1550167.47	1652394.89
210204	Ажилгүйдлийн даатгал	370687.63	437963.15
210205	Эрүүл мэндийн даатгал	3775889.52	4799291.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16987100	21997414
210301	Гэрэл, цахилгаан	1223900	1171114
210302	Түлш, халаалт	15363200	20505300
210303	Цэвэр, бохир ус	400000	321000
2104	Хангамж, бараа материалын зардал	1758049	0
210401	Бичиг хэрэг	90300	0
210402	Тээвэр, шатахуун	380300	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	780870	0
210404	Ном, хэвлэл	62000	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	372579	0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	72000	0
2105	Нормативт зардал	14165645	31486950

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20000	0
210502	Хоол, хүнс	13452425	31486950
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693220	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150000	0
210604	Урсгал засвар	150000	0
2107	Томилолт, зочны зардал	93500	0
210702	Дотоод албан томилолт	93500	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1464380	789810
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1140380	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	789810
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7802044.54	38490029.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	28298015
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2339530	2449770
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5462514.54	7742244.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23923506	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23923506	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23923506	0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	59741931.14	-1477229.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	433600	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	433600	0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-433600	0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	59308331.14	-1477229.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	339033285	315589000
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63313885	0
120	Нийтлэг татварын бус орлого	1578485	0
120009	Бусад орлого	1578485	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	61735400	0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	61735400	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275719400	315589000
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	264723985	315589000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	36961000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264723985	278628000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10995415	0

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10995415	0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	277670464	315589000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277670464	315589000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253746958	315589000
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188570359	218185000
210101	Үндсэн цалин	116201300	163614408.1
210102	Нэмэгдэл	59692559	40206671.11
210104	Урамшуулал	12676500	14363920.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26635700	25540700
210201	Тэтгэврийн даатгал	18743900	16740500
210202	Тэтгэмжийн даатгал	1972900	2115100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1578200	1711500
210204	Ажилгүйдлийн даатгал	394800	428300
210205	Эрүүл мэндийн даатгал	3945900	4545300
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12423900	22326400
210301	Гэрэл, цахилгаан	1223900	1320212
210302	Түлш, халаалт	10800000	20606188
210303	Цэвэр, бохир ус	400000	400000
2104	Хангамж, бараа материалын зардал	1133279	0
210401	Бичиг хэрэг	90300	0
210402	Тээвэр, шатахуун	380300	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	74100	0
210404	Ном, хэвлэл	51600	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	372579	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	164400	0
2105	Нормативт зардал	16473020	39060000
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54400	0
210502	Хоол, хүнс	15903620	39060000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	515000	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150000	150000
210604	Урсгал засвар	150000	150000
2107	Томилолт, зочны зардал	93500	0
210702	Дотоод албан томилолт	93500	0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1739600	592000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1415600	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	592000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6527600	9734900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	7034900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6527600	2700000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23923506	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23923506	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23923506	0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	61362821	0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	61362821	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59467248	111405520.8	61894719.16	232767488
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59467248	111405520.8	61894719.16	232767488
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	-1477229.92	-1477229.92
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59467248	111405520.8	60417489.24	231290258
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59467248	111405520.8	60417489.24	231290258
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59467248	111405520.8	60417489.24	231290258
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-1477229.92	-1477229.92
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59467248	111405520.8	58940259.32	229813028.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	315589000	315589000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315589000	315589000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315589000	315589000
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217122400	218185000
210101	Үндсэн цалин	180175700	163614408,11
210102	Нэмэгдэл	32036800	40206671,11
210104	Урамшуулал	4909900	14363920,78
2102	Ажил олгогчоос ндш	27140500	25540700
210201	Тэтгэврийн даатгал	18575400	16740500
210202	Тэтгэмжийн даатгал	2115100	2115100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1739300	1711500
210204	Ажилгүйдлийн даатгал	428300	428300
210205	Эрүүл мэндийн даатгал	4282400	4545300
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22129200	22326400
210301	Гэрэл, цахилгаан	1223900	1320212
210302	Түлш, халаалт	20505300	20606188
210303	Цэвэр, бохир ус	400000	400000
2104	Хангамж, бараа материалын зардал	39060000	39060000
2105	Нормативт зардал	39060000	39060000
210502	Хоол, хүнс	39060000	39060000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150000	150000
210604	Урсгал засвар	150000	150000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592000	592000
210801	Мэдээлэл технологийн үйлчилгээ	592000	592000
210802	Бараа үйлчилгээний бусад зардал	9364900	9734900
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6694900	7034900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2700000	2700000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	315589000	315589000
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	278628000	278628000
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36961000	36961000
132001	Орон нутгийн төсвөөс	36961000	36961000
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг нь Хүүхэд бүрийг амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хүүхдийн хөгжлийг дэмжих, багш, ажилтны ёс зүйг эрхэмлэн ажлын байранд хөгжүүлэх, багш ажилчид болон хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүүхэд бүрийн амжилттай суралцахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллаж хүүхдийн хөгжлийн дэмжих
- 5 настай хүүхдийн бүрэн хамруулах ажлыг амжилттай хэрэгжүүлэн, хичээл үйл ажиллагааг танхим болон цахим, зайн, хувилбарт сургалтуудыг зохион байгуулах.
- Багш ажилтны ёс зүйг эрхэмлэн ажлын байранд хөгжүүлэх боломжийг бүрдүүлэн, багш бүр дасгал даалгаврын сан бүрдүүлж, багш ажилчид техник технологийн хэрэглээг сайжруулан бие биенээсээ, бусдаас суралцах
- “Эрүүл мэнд-Эрүүл хоол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, амин дэмээр баялаг хоол хүнсээр үйлчлэн хүүхдийн дархлааг дэмжих.
- Сургуул цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулан хамтын ажиллагааг бэхжүүлж 5 настай тойргийн хүүхдийг сургуульд амжилттай бэлтгэх

Тус цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд бэлтгэл бүлэгт-24, ахлах бүлэгт-28, дунд бүлэгт-25, бага бүлэг-29, хувилбарт бүлэгт 45, бүгд 151 сургуулийн өмнөх насны хүүхдүүд хамрагдаж, нийт 17 багш ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр

тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.9 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2203,0	693,0	-1510,0
Бараа материал	31172,5	17618,3	-13554,2
Үндсэн хөрөнгө	200018,4	213196,8	13178,4
Нийт хөрөнгө	233393,9	231508,2	-1885,7
Өр төлбөр	626,4	217,9	-408,5
Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/	232767,5	231290,2	-1477,3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн/	233393,9	231508,2	-1885,7

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага дансны үлдэгдэл тооцоо нийлж баталгаажуулсан 0.7 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн байна.
- ✓ Бараа материалын дансаар 46,3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хөрөнгө бэлтгээгүй, 39,0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 20,9 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлж, оны эцэст 17.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 469.5 сая төгрөгийн төсвийн тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 153.9 сая төгрөгөөр бууруулж, нийт 315.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төсөлд багш нарын 5 жилийн тэтгэмжийг илүү тооцож төлөвлөсөн нь төсвийн төслийг бууруулах шалтгаан болсон.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 315,6 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 315,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 315.6 сая төгрөг буюу 100,0 хувь үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээний зардалд зарцуулсантай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71806/81834	201721,9	201721,9	0.0	100.0
2	71806/81835	113867,1	113867,1	00	100,00
Нийт дүн		315589,0	315589,0		100,00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг Эл би альфа экстэйншин аудит ХХК-ны аудитор Н.Дэмбэрэлдорж 2023 оны 01 дүгээр сарын 24-наас 02 дугаар сарын 06 –ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 110.0 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 128 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 8 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн 27.0 сая төгрөгийн төлбөр, зөрчил, залруулга, зөвлөмжийг илрүүлж төлбөрийн акт 1.9 сая төгрөг, залруулга 0.07 сая төгрөг, 25.0 сая төгрөгийн зөвлөмжийг бичиж хэрэгжүүлэх хугацаатай үүрэг өгөгдсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1900,0	1	1900,0	100,0
Албан шаардлага					
Зөвлөмж	1	25000,0	1	25000,0	100,0
Нийт дүн	2	26900,0	2	26900,0	100,0

4. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэхүйц материаллаг хэмжээний залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 2.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж ажиллах 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтын тайлан, Замын хуудас, талоны бичилтээс үзэхэд тухайн шатахууныг зайлшгүй шаардлагатай биш ажил үйлчилгээнд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, зайлшгүй шаардлагатай сургалт семинарт явах бол харьяа дээд газрын шийдвэрээр,

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн хяналтын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж зарцуулж хэвших.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахуун зарцуулалтад тавих дотоод хяналт сул, жолоочийн замын хуудас, талонаас үзэхэд зайлшгүй шаардлагатай ажил үйлчилгээнд төдийлэн зарцуулагдаагүй дутагдал ажиглагдаж байна	1	2604.5					1	2604.5
Дүн	1	2604.5	-	-				2604..5

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР:  **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ЭЛ БИ АЛЬФА ЭКСТЭЙНШИН АУДИТ ХХК-НИЙ

ПЮА0073 9066454

АУДИТОР:  **Н.ДЭМБЭРЭЛДОРЖ**